

<b>Агуулга</b>	
1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн товч мэдээлэл.....	2
1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал.....	3
2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	8
3.1 Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
3.1.1 Агаар.....	8
3.1.2 Хөрс .....	9
3.1.3 Ус .....	9
3.1.4 Биологийн олон янз байдал, ургамал, амьтан бусад .....	9
3.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа .....	10
4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	20
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	23
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	26
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	1



нарийвчилсан хайгуулын ажлыг эхлүүлж 2011 оны 01-р сарын 01-ны байдлаар нүүрсний нөөцийг гадаргуугаас 20-350 метрийн гүнд 7км урт талбайд нийт 5 нүүрсний давхраас тогтоож багтай (А) зэрэгт хамаарах 1.3 сая тн, бодитой (В) зэрэгт хамаарах 113.41 сая тн, боломжтой (С) зэрэгт хамаарах 45.32 сая тн буюу ордын хэмжээнд нийт 160,040,752 тн чулуун нүүрсний нөөцийг тогтоогоод байна.

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь 2019 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан, 2023 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулуулж, холбогдох байгууллагаар батлуулсан. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн авран хамгаалах хайгуул судалгаа, малтлага судалгааны ажлуудыг жил бүр шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Төслийн талбайд шинээр төлөвлөн баригдаж буй дэд бүтцийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2019 онд хийлгэж холбогдох яамаар батлуулсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.

## 1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтай, урд талаараа БНХАУ-тай хил залгадаг ба нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 116 мянган ам километр болно. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны өмнө талын тэгш өндөрлөг, дунд хэсгээрээ Их нуруудын хотгорын төгсгөл тал хээр, өмнөд хэсгээрээ Алтайн цаад говийн цөлөрхөг хэсэгт хамаардаг.

Баянхонгор аймаг нь хөрс, цаг уурын олон бичил мужид хуваагддаг. Нар салхины эрчим хүчний нөөц сайтай ба Умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эрс тэс уур амьсгалтай.

### Физик газар зүй


Хотгорын чулуун нүүрсний орд засаг захиргааны хувьд Монгол улсын баруун өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужын баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд оршино. Орд нь Говь-Алтайн нурууны дунд хэсэг (Баянцагааны нуруу, Шинэжинси уулын хооронд) оршдог тул ордын үндсэн хэсэг нь уул, толгодорхог, гадаргуутай районд багтах бөгөөд далайн түвшинээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана. Тус уурхайн талбайн хамгийн өндөр цэг нь Саманд уул ба түүний үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 2347 метр юм. Талбайн гадаргуу нь гуу, жалгаар нэлээд хэрчигдэлтэй, тэдгээрийн адгуудад хошуурсан туугдсууд үүсч, өөрийн гэсэн онцлогтой чулуурхаг товгорхог гадаргууг үүсгэсэн байдаг. Орд газар нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг.

Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийн хамран говь хангайн бүсийг дамнан оршдог аймаг юм. Иймд нутаг нь уул тал хөндий хосолсон хэлбэр бүхий гадаргатай. дунд хэсэг Шинэжинст сум нь



өргөрөгийн 44°44'10", уртрагийн 100°23'40" солбицолд орших бөгөөд далайн түвшинээс дээш 1630 метр өндөрт байрладаг бөгөөд зүүн хойд талаараа Алтайн нурууны уулс, төв хэсгээр Улаанхан, Хартолгой, Хөндлөн зэрэг уулс, Өргөөтийн талууд оршино. Тус сумын хамгийн өндөр цэг Их Богд Уул 3957 метр, хамгийн нам цэг нь далайн түвшинээс дээш 1200 метр өндөр нутгийн захад оршино.

Зураг №3. Ашиглалтын талбайн агаар сансрын зураг



### Уур амьсгал

Шинэжинст сум нь нутаг дэвсгэрийн мужлалаар говийн бүс, мелиорацийн мужлалаар умард говийн бүсэд, цаг уурын мужлалаар нэн хуурай дулаавтар мужид багтаж байна. Ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсд багтана. Уур амьсгалын тодорхойлолтыг Шинэжинст цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг үндэслэн бичив. Цаг уурын шинэжинст өртөө нь 1972 оны сүүлчээр байгуулагдсан манай улсын цаг уурын сүлжээний нэг тулгуур цэг бөгөөд хойд өргөрөгийн 44°03', зүүн уртрагийн 99°16', далайн түвшнээс 2219,2 метр өндөрт оршино. Энэ бүс нутаг жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас ховор хэт хуурай. Жилдээ 120-180мм хур тунадас ордог бөгөөд хамгийн хүйтэн нь 1-р сард -30-35°C, харин зундаа 7-8-р сард хамгийн +25+30°C байдаг. Жилийн дундаж температур 0-(+1)°C- хэлбэлзэх ба салхины чиглэл баруун, баруун урдаас зүүн, зүүн хойшоо байдаг, дундаж т хурд нь 2.8-7.3 м/сек-ийн хооронд байна.

Өвөл: Эхний цас оролт 10-р сарын эхэнд орох ба хожуу цас оролт 10-р сарын 28-нд ордог. Эцсийн цас оролт 2-р дүгээр сарын 11-нд орох ба хожуу цас оролт 5-р сарын 15-нд ордог. Цасан бүрхүүлтэй өдрийн тоо 49 өдөр, цасан бүрхүүлийн нягт нь 0,6 г/см<sup>3</sup> байдаг. Эцсийн хүйтрэл 5-р сарын 17-ны үеэр тохиолдох бөгөөд хүйтрэлгүй хугацааны дундаж үргэлжлэл нь 147 хоног байна.

Хавар: Тус сумын нутаг 4-р сарын 15-ний үеэр хавар эхэлж, 5-р сарын 3-ны үеэр шувтрах бөгөөд нийтдээ 18 хоног үргэлжилнэ.

Зун Харин зуны улирал 5-р сарын 3-ны үеэс хоногийн дундаж агаарын температур харин зундаа 7-8-р сард хамгийн халуун  $+10^{\circ}\text{C}$  давж дулаарахаас эхлэн 10-р сарын 2 буюу  $+10^{\circ}\text{C}$ -ийг давж сэрүүсэх хүртэл 152 хоног үргэлжилнэ.

Намар: Хоногийн дундаж агаарын температур  $+10^{\circ}\text{C}$ -аас доошлох буюу  $-5^{\circ}\text{C}$  болж сэрүүсэх хүртэл хугацааг намрын улирал гэж монгол орны уур амьсгалын мужлалаар тогтоожээ. Тус сумын нутаг намар 10-р сарын 2-ний үеэр эхэлж, 11-р сарын 13-ний үеэр дуусаж дунджаар 41 хоног үргэлжилнэ.

### Хөрс

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний төрөл, тархац үржил шим тариалангийн бүс, дэд бүс бүрт харилцан адилгүй байдлаар тархсан байдаг. Талбайн баруун талаар ухаа гүвээ толгодын маш нимгэн ялзмагт үеийн давхрагатай, карбонатлаг, цөлөрхөг хээрийн бор хөрс, дунд хэсгээрээ тал газрын ба уулсын хоорондох маш нимгэн ялзмагт үе давхрагатай, зузаан шороон үетэй. Талбайн баруун урд талдаа намхан уул, толгодтой бусад хэсэгтэй гүвээлэг болон тэгш, гадаргадаа жижиг үйрмэг чулуутай (10-15%). Өнгөн хөрс нь салхины элэгдэлд бага зэрэг орсон. Хөрсний ялзмагт үеийн зузаан 12 см, шороон үеийн зузаан нь 1.0-1.7 байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн нийт талбайд элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уур амьсгалын нөлөөгөөр говийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш нимгэн байдаг.

### Ургамал

Уурхайн талбайд ургамалын нөмрөгийн хувьд уулыг хээрийн Таана-заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат, таана-үетэн-заримдаг сөөгөнцөрт гэсэн 2 төрлийн хэв шинжүүд бүлгэмдлүүд 15-25% бүрхэц үүсгэн 0.85-1.06ц/гаургацтай ургаж байна. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ. Голлон таана баглуур ургах ба хялгана, агь, тэсэг сийрэг бөгөөд тачир тархалттай байна.

### Амьтны аймаг

Шинэжинст сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтны олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархацын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтадаар нилээд баялаг, уул, асга, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа,

чогчиг, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавьж болон жижиг далавчитнаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

## 2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Засаг захиргаа, нутаг дэвсгэр:** Баянхонгор аймаг нь 1941 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 81- р тогтоолоор шинээр гурван аймаг байгуулагдсаны нэг юм. Баянхонгор аймаг нь 116,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 20 сум, 105 багтай. Аймгийн төв Баянхонгор хот.

Баянхонгор аймаг нь урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Говь- Алтай, баруун хойд хэсгээр Завхан, хойд талаараа Архангай, зүүн, зүүн хойд талаараа Өвөрхангай, зүүн урд хэсгээрээ Өмнөговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Баянхонгор хот нь Улаанбаатар хотоос 630 км зайтай.

**Хүн ам:** Аймгийн суурин хүн амын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 89643 үүнээс 45453 /50,7%/ эмэгтэй, 44190 /49,3%/ эрэгтэй Баянхонгор аймагт амьдарч байна. Нийт хүн амын 32665 нь аймгийн төвд, 10017 нь сумын төвд, 46961 хүн нь хөдөө амьдарч байна.

Өрхийн тоо 26737 болж эрэгтэй өрхийн тэргүүлэгтэй өрх нь 19432 / 72,7%/, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй 7305 / 27,3%/ өрх байна. Нийт өрхийн 9746 нь аймгийн төвд, 3057 нь сумын төвд, 13934 өрх нь хөдөө амьдарч байна.

Баянхонгор аймгийн дундаж наслалт 2020 онд 70.9 байсан бол 2022 онд 71.7 болж 0.8 жилээр нэмэгдсэн байна. Эрэгтэй дундаж наслалт 2022 онд 68.4, эмэгтэй дундаж наслалт 73.7 байгаа нь эмэгтэйчүүд 5.3 жилээр илүү урт насалж байгааг харуулж байна.

**Боловсрол:** Баянхонгор аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын мэдээгээр 2022 2023 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 32 сургуульд 19410 суралцагч, сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллагад 6824 хүүхэд сурч хүмүүжнэ.

Сургуулийн бүлэг дүүргэлт 28, цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 32 байгаа бол цэцэрлэгийн хамран сургалт 87, сургуулийн хамран сургалт 98 хувьд хүрчээ. ЕБС-д 973 багш ажиллаж байгаа нь багшийн хангалт 99 хувь, СӨБС 210 багштай үйл ажиллагаа явуулж байгаа нь багшийн хангалт 98 хувьтай байна.

**Эрүүл мэнд:** 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд 1503 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 214 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 94.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 5.1 хувь нь төржээ. Нялхсын эндэгдэл 2022 оны байдлаар 16 гарчээ. Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт 8128 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 913.3 байгааг өнгөрсөн оны мөн үетэй (2043.6) харьцуулахад 2.6 дахин буурч, коронавирусийн халдварын шалтгаант 2 нас баралт бүртгэгдсэн байна. Нийт 14182 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 22.6 хувийг алсын, 7.4 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо өсөж, нийт дуудлагад эзлэх осол гэмтлийн дуудлага буурсан байна.

**Идэвхитэй ажил хайгч иргэд:** 2022 оны байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1027 болж өмнөх сараас 56 хүнээр буюу 5.4 хувиар буурчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 564 буюу 54.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 74.9 хувь буюу 770 иргэн, 45 дээш насныхан 257 иргэн 25.1 хувийг эзэлж байна. Шинэ ажлын байранд нийт 301 иргэн ажилд орсон бөгөөд үүний 50.8 хувь буюу 153 нь эмэгтэйчүүд байна.

**Мал аж ахуй:** Мал тооллогын дүнгээр 2022 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн нийт дүн 3719,6 мянга болж, 2021 оны нийт дүнгээс 17.6 хувь буюу 691.5 мянган толгойгоор өслөө. Тооллогын



дүнгээр адуун сүргийн тоо 160.4 мянга, үхэр 223 мянга, тэмээ 45.5 мянга, хонь 1108 мянга, ямаа 2182,7 мянган толгой болж өссөн.

2022 оны тооллогын дүнгээр 15.3 мянган малтай өрх тоологдож, өмнөх оныхоос 154 өрх буюу 0.9 хувиар буурсан байна. Нийт малтай өрхийн 85.0 хувь буюу 13.1 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэрээ болгож байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 211 өрх буюу 7.5 хувиар өслөө. 2022 оны тооллогын дүнгээр 22.6 мянган малчин тоологдлоо. Нийт малчдын 12.6 мянга буюу 55.3 хувь нь эрэгтэй, 9923 мянга буюу 44.7 хувь нь эмэгтэй малчид байна.

2022 оны том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 3737 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0.1 хувийг эзэлж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 11, адуу 226, үхэр 515, хонь 1188, ямаа 1797 толгой тус тус хорогджээ

**Газар тариалан:** Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 31- ний байдлаар 1692.6 тонн төмс, 814.1 тонн хүнсний ногоо хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс 0.07 тонн ( 0.04 % )-оор, хүнсний ногоо 204.1 тонн ( 20.1 % )-оор тус тус буурсан байна.

**Аж үйлдвэр:** Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2022 оны 11 дүгээр сард өссөн дүнгээр 72 тэрбум 40 сая төгрөгт хүрчээ. өмнөх оны мөн үеэс 20 тэрбум 488 сая төгрөг буюу 28.4 хувиар өссөн байна. Нийт үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 21 тэр бум төгрөг буюу 33.8 хувиар өссөн, боловсруулах аж үйлдвэрийн борлуулалт -417,4 сая төгрөг буюу 22,6 хувиар буурсан, цахилгаан, хий, уур, агааржуулалтын борлуулалт -719,6 сая төгрөг буюу 15,4 хувиар буурсан, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны борлуулалт 428,2 сая төгрөг буюу 18.5 хувиар өссөн байна. Үйлдвэрийн газрууд 6720,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 6720,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн он мөн үеэс 24,6 сая буюу 0,37 хувиар нэмэгдсэн байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагчидын тоо өмнөх оны мөн үеэс 537 болж 6 хүнээр буурсан үзүүлэлтэй байна.

**Төсвийн орлого, зарлага:** 2022 оны байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 23806.4 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 6104.5 сая төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн байна. 2022 оны нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянлиг, Баянговь, Богд, Баянбулаг, Бууцагаан, Бөмбөгөр, Галуут, Заг, Эрдэнэцогт, Жаргалант, Өлзийт, Жинст, Шинэжинст Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан сумууд давуулан биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: газрын төлбөр 79.1 сая төгрөг, малын тоо толгойн татвар 302.5 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 37.7 сая төгрөг, агаарын бохирдол (нүүрс) 8.4 сая төгрөг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 3.3 сая төгрөг, түгээмэл тархацтай АМНАТ 10.3 сая төгрөгөөр тус тус тасарч, НӨАТ 163.5 сая төгрөг, орон нутгийн автозам ашигласны хураамж 36.9 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 129.8 сая төгрөг, ус ашигласны төлбөр 33.8 сая төгрөг. хог хаягдлын хураамж 21.6 сая төгрөг, Ашигт малтмал олборлосны татвар 0.2 сая төгрөг. хүү торгууль 113.1 сая төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр 3569.3 сая төгрөг, газрын дуудлага худалдааны төлбөр хураамж 42.5 сая төгрөгөөр тус тус давуулан биеллээ. Нийт орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар 7.7 хувь, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 2.5 хувь, хүү торгууль 6.6 хувь. ЦХХТА орлого (суутган) 31.5 хувь, ААНОАТ (60%) 3.5 хувь, бусад төлбөр хураамж 31.1 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2022 оны байдлаар арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл 264.794.7 сая төгрөг байгаагийн 5922.2 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 4624.2 сая төгрөг нь чанаргүй зээл байна. 2022 оны байдлаар нийт

хадгаламжийн үлдэгдэл 133208.2 сая төгрөг болжээ. Үүний 18925.5 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 114282.7 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

### 3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2019 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

#### 3.1 Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Хотгорын нүүрсний орд ашиглах үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн тодорхойлохдоо НҮБХХБ болон байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлал” зэргийг ашиглан гүйцэтгэгдсэн тооцоо, судалгаа үнэлгээний дүнг нэгтгэн тооцоолсон болно. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчинд үзүүлэх төслийн үйл ажиллагаа, түүний байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүртэй харилцан үйлчлэлцэх боломжийг магадлан жагсаахдаа “Баруун Хуасай” ХХК-ийн шинжээчид болон төслийн баг бүрэлдэхүүн хамтран гүйцэтгэсэн болно.

##### 3.1.1 Агаар

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

##### Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

##### Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр хээрийн анги орчим
- Шинэжинст сум, багийн оршин суугчид
- Амьтан



- Ургамал

### 3.1.2 Хөрс

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Шатахуун түгээх станц, авто засварын төв зэрэг нь хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй тул талбайг цементлэх шаардлагатай.

#### Хөрс бохирдолт

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон
- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

#### Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

### 3.1.3 Ус

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорхи усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

#### Гадаргын ба гүний ус

- Гадаргын ба гүний усанд одоогоор нөлөөлөл багатай

#### Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал
- Амьтан ургамал

### 3.1.4 Биологийн олон янз байдал, ургамал, амьтан бусад

#### Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, хөрс хуулалт, автомашины хөдөлгөөн зэргээс ургамал талхлагдах доройтох зэрэгцээ тоос, ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож ургамлан бүрхэвч багасах нөлөөлөл үүснэ. Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ,

автомашинны хөдөлгөөн зэргээс шувууд, амьтад уурхайн талбай болон ойр орчмын талбайгаас дайжих нөлөөлөл үүснэ.

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд
- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт / нүүрс ачих тээвэрлэх /
- Хаягдал аж ахуйн /нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго /
- Талбайн гадаргын ус зайлуулах систем
- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

1. Уурхай орчмын ургамал амьтан

3.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа

Тус төслийн үйл ажиллагааны үйлдлийн хүрээ байгалийн хам бүрдлүүдэд үзүүлж болзошгүй нөлөөллийг НҮБ-ийн Ази номхон далайн Эдийн засаг, Нийгмийн комиссоор гаргасан байгаль орчны үнэлгээ хийх гарын авлагад заагдсан матрицын аргаар тооцоолох, төслийн бүтээгдэхүүн хэсгийг босоо тэнхлэгийн дагуу авч үзсэн. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл ялгаатай байх тул эдгээрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй нөлөөллийг тусган авч үнэллээ. Болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-5 баллаар үнэлэх ба дараах тэмдэглэлийг ашигласан болно. Үүнд:

1. Сөрөг нөлөөлөлгүй
2. Сөрөг нөлөөлөл бага
3. Сөрөг нөлөөлөл дунд зэрэг
4. Сөрөг нөлөөлөл их
5. Онц уршигтай сөрөг нөлөөлөлтэй

**Хүснэгт-3. Төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг доорх хүснэгтэд үзүүлэв.**

Төслийн ажиллагаа	үйл	Нөлөөлөлд өртөх объектууд	Шалгуур			Нийт түвшин
			Хэмжээ	Хамрах хүрээ	Давтамж	
Шимт хуулалт	хөрс	Агаарын чанар	1	1	2	2
		Усны чанар	0	0	0	0
		Усны нөөц	0	0	0	0
		Ургамлын бүтэц	3	1	3	9
		Амьтны аймаг	1	1	3	3
		Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
		Геологийн тогтоц	0	0	0	0
Шимт хадгалалт	хөрс	Агаарын чанар	1	1	2	2
		Усны чанар	0	0	0	0
		Усны нөөц	0	0	0	0
		Ургамлын бүтэц	1	1	3	3
		Амьтны аймаг	1	1	1	1
		Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
		Геологийн тогтоц	0	0	0	0
Ухаж бэлтгэх	ачихад	Агаарын чанар	1	1	3	3
		Усны чанар	2	2	3	12
		Усны нөөц	2	2	3	12
		Ургамлын бүтэц	1	1	3	3
		Амьтны аймаг	1	2	1	2
		Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
		Геологийн тогтоц	3	2	3	18

Өрөмдлөг тэсэлгээ	Агаарын чанар	1	2	3	6
	Усны чанар	2	2	3	12
	Усны нөөц	2	2	3	12
	Ургамлын бүтэц	1	1	3	3
	Амьтны аймаг	1	1	3	3
	Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
	Геологийн тогтоц	2	2	2	8
Хурдас чулуулгийг тээвэрлэх	Агаарын чанар	2	2	2	8
	Усны чанар	0	0	0	0
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	2	2	8
	Амьтны аймаг	2	2	2	8
	Хөрсний хими физик чинж чанар	2	2	2	8
	Геологийн тогтоц	0	0	0	0
Олборлолтын үйл ажиллагаа	Агаарын чанар	1	1	3	3
	Усны чанар	2	1	3	6
	Усны нөөц	2	1	3	6
	Ургамлын бүтэц	2	1	3	6
	Амьтны аймаг	1	1	1	1
	Хөрсний хими физик чинж чанар	1	1	3	3
	Геологийн тогтоц	3	3	3	6
Шатах тослох материалын агуулах	Агаарын чанар	2	1	2	4
	Усны чанар	2	1	2	4
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	1	3	6



	Амьтны аймаг	1	1	1	1
	Хөрсний хими физик чинж чанар	2	1	3	6
	Геологийн тогтоц	0	0	0	0
Дотоод зам	Агаарын чанар	2	2	3	12
	Усны чанар	1	1	1	1
	Усны нөөц	1	1	1	1
	Ургамлын бүтэц	3	2	3	18
	Амьтны аймаг	2	1	2	4
	Хөрсний хими физик чинж чанар	3	2	3	18
	Геологийн тогтоц	0	0	0	0
Уурхайн гадаад тээвэрлэлт	Агаарын чанар	1	3	3	9
	Усны чанар	1	1	1	1
	Усны нөөц	0	0	0	0
	Ургамлын бүтэц	2	3	3	18
	Амьтны аймаг	2	3	2	12
	Хөрсний хими физик чинж чанар	1	3	3	9
	Геологийн тогтоц	0	0	0	0

Болзошгүй нөлөөллийн үнэлгээний хүснэгтээс харахад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны хам бүрдэл хэсэгт үзүүлж байгаа нөлөөллийн дундаж онооны утгатай үйл ажиллагаанд дотоод зам, малталт, олборлолтын үйл ажиллагаанууд орж байна.

#### 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажиллаж байна.

Тус төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 6.3 сая тонн нүүр олборлохоор төлөвлөсөн.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	1. Агаарын чанар	Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгонд байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн тээврийн замыг тогтмол чийгшүүлж усалгаа хийх	М <sup>3</sup>	99,74	20,000	4,000,000	Үйл ажиллагааны туршид Хуурайшилтын үед	
2.		Нүүрс тээвэрлэх үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсч, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох /уурхай дотор 40км.цагаас хэтрэхгүй байх/ Замын хөдөлгөөний мэдээлэх тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засч сайжруулах	ш	150,000	40	6,000,000	2 дугаар улиралд	

3.		Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанар нөлөөлөх	Авто тээврийн агаарын бохирдлын төлбөр төлөх	Ш	25,000	4	100,000	Үйл ажиллагааны туршид		
4.			Техникийн үзлэгт бүрэн хамруулах	ш	200,000	4	800,000	Үйлчилгээний тэрэг бүрийн тогтоосон хугацаанд		
5.	2.Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Ил уурхайн ашиглалтаас газрын доорх ус хомсдох	Уурхай орчмын уст цэгийг хамгаалалтад авах, тохижуулах	ш	7,000,000	1	7,000,000	Жилийн эцэст		
6.			“Усны зохистой хэрэглээ” сэдэвт сургалт -Шинэ ажилтны сургалтаар мэдээлэл хүргэх				Дотоод зардал	Шинэ ажилтан ирэх бүрд		
7.			Булгийн эхийн хог хаягдлыг цэвэрлэх хамгаалах	Нөлөөллийн бүсэд ойр орших булаг	ш	100,000	1	100,000	3 болон 8 дугаар саруудад	
8.			Сумын хэмжээнд ашиглагдаж байгаа ундны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээнд хамруулан орон нутгийн иргэдэд танилцуулах	Сумын зүүн хойд худаг Задгай булаг	ш		2	ОХШХ	6 болон 11 дүгээр саруудад	
9.	3.Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс, ургамлан нөмрөг бохирдох	Засварын цэг, ШТМ-ын агуулах, ШТС-ийн талбайн засвар арчлалт хийх, цемент бетон суурьтай болгох	мкв	200,000	100	20,000,000	2-3 дугаар улиралд		



10.		Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Ахуйн шингэн хаягдлыг хаях зайлуулах				Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан	Үйл ажиллагааны туршид	
11.	4.Газрын хэвлий	Хөрс хуулалтын явцад тухайн талбай дахь хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, 5м-ээс доош өндөртэй хадгалж, усалгаа хийх, стандартын дагуу хэлбэржүүлж хамгаалах				Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Үйл ажиллагааны туршид	
12.	5.Ургамлан нөмрөг	ШТМ, Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс, ургамлан нөмрөг бохирдуулах	ШТМ-аар бохирдсон хөрсийг хуулж цуглуулах, биологийн бэлдмэлээр бохирдлыг бууруулах	мкв	20,000	100	2,000,000	Үйл ажиллагааны туршид	
Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал: 40,000,000									

**6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хотгорын уурхайн олборлолтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр уурхайн олборлолт явагдаж буй бүсэд 2024 онд гадаад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичгүүд
---	---	-------------------------------	--------------------------	-------------	------------	---------------------	------------------	--------------------------------	----------------------------------

	1	2	3	4	5	6	7	8	9
1	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу гүйцэтгэх	Усалгаа хийх, олон наст ургамал тариалах	М <sup>2</sup>	100	20,000	5,000,000	Ургамал ургалтын хугацаанд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 MNS
2	Кемпийн газрын 0,3 га талбайд мод тарих, ногоон байгууламж бий болгох	2023-2024- 2025 онуудад тус бүр 0,1 га талбайгаар нэмэгдүүлнэ	Хайлаас, улиас болон бусад түргэн ургалттай навчит	ш	1,000	5,000	5,000,000	2024оны 5 дугаар сар	Газрын тухай хууль, БОА-ийн зөвлөмж
3	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	Сумын төвийн хойд талын хамгаалалтын зурваст мод тарих	модоор хамгаалалтын н зурвасны талбайн хэмжээг нэмэгдүүлэх	ш	2,500	4,000	12,000,000	2024 оны 5 дугаар сар	МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг
Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал:22,000,000төг									

7. **БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нөхөн сэргээлт 2024 хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймгийн БОАЖГ-аас санал болгосон талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт	Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт ТХГ-т “Дунд ногоон толгой” нэртэй газар	10га	20,000,000	20,000,000	2024 он	Нөхөн сэргээлт-2024 хөтөлбөр
2.	Сумын төвийн зүүн хойд ууланд нутагшдаг янгир, зэрлэг ан амьтдад өвс тэжээл бэлдэх	Биотехникийн арга хэмжээ	Өвс тэжээл тавьж өгөх	100 боодол өвс	5,000,000	5,000,000	2024 оны 3, 11 дүгээр сар	Амьтны тухай хуулийн 6.1.8
3.	Мазаалайд хоол бэлдэж өгөх	Биотехникийн арга хэмжээ	Хорголжин тэжээл тавьж өгөх	30 уут хорголжин тэжээл	2,000,000	2,000,000	2024 оны 3 дугаар сарын 15	Амьтны тухай хуулийн 6.1.8
Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал: 27,000,000 төг								

**8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хотгорын уурхайн MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбай болон нөлөөллийн бүсэд байгаа айлуудад нөхөн төлбөр олгох ажлыг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан шийдвэрлэхээр төлөвлөж байна.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Ц.Төмөрбат		Нөхөн олговор			Харилцан тохиролцоно	2024 оны 4 дүгээр улирал	
2	Ч.Чулуун		Нөхөн олговор					
3	Х.Бат-Ирээдүй		Нөхөн олговор					
4	Т.Батцэцэг		Нөхөн олговор					
5	Д.Эрдэнэ-Очир		Нөхөн олговор					
6	Х.Сүхбаатар		Нөхөн олговор					
7	Х.Мөнхдалай		Нөхөн олговор					
8	Д.Хүрэлбаатар		Нөхөн олговор					
9	Д.Үйтүмэн		Нөхөн олговор					
	Нийт					Үйл ажиллагааны зардлаас		

**9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу манай компани хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, ШУА-Археологийн Хүрээлэнтэй хамтарч археологийн хайгуул судалгаа, археологийн авран



хамгаалах малтлага судалгааны ажлыг 2011-2014 онуудад, Палеонтологийн хүрээлэнтэй хамтран 2023 оны 10 дугаар сард хайгуулын малтлага судалгаа хийлгэсэн.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Соёлын өв олдсон тохиолдолд холбогдох газарт мэдээлнэ.	Үйл ажиллагааг түр зогсоож холбогдох газарт мэдээлэх			500,000	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.	Палеонтологийн дурсгал					500,000		
	Нийт					1,000,000		

#### 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж Тоо хэмжээ Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<i>1.Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>					
Хүчтэй салхи шуурганаас аюул, осол гарах	Хүчтэй салхи, шуургатай үед үйл ажиллагааг түр зогсоох, аян замд гарахгүй байх	Төслийн талбай болон ойр орчимд	ҮАЗ	2024	Компаний аялалын журам, Гамшигаас хамгаалах тухай хууль, 2017.02.02
	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангаж хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгох	Уурхайн ажилчид	3,000,000	2024	

Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Ил задгай гал гаргахгүй байх, хэрэгцээт газруудад галын самбар, сараа, гал унтраагуур байршуулах	Уурхайн объект сууцууд	3,000,000	2024 оны 1 дүгээр улирал	Галын аюулгүй байдлын тухай хууль,
<i>2.Шатахуурын агуулахын ослоос урьдчилан сэргийлэх</i>					
Шатахууны агуулахад аюул осол гарах	Галын дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулах Гал унтраагуур, галын сараа шаардлагатай газруудад байрлуулах	Шатахууны агуулах, шатахуун түгээгүүр	7,000,000	2024 оны 1 дүгээр улирал	Галын аюулгүй байдлын тухай хууль,
	Аврах гарцын чиглэл, цуглах цэг, дуут дохио шаардлагатай газруудад байрлуулах		3,000,000	2024 оны 1 дүгээр улирал	Галын аюулгүй байдлын тухай хууль,
<i>2.Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>					
Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмууд боловсруулж, дагаж мөрдөх	Уурхайн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах	ХАБЭА-н төлөвлөгөө	ХАБЭА-н тухай хууль
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх				MNS 4969:2000
	Ажиллагсдыг алжын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	3,000,000	ХАБЭА-н төлөвлөгөө	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
<i>3.Химийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>					
Химийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах	Тэсрэх бодисын агуулахад 24 цагийн харуул хамгаалалт ажиллуулах	Тэсрэх материалын агуулах	Гэрээний дүнгээр	Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр	ХАБЭА-н тухай хууль
	Химийн бодисын ХАЛМ, Шаардлагатай үед холбоо барих мэдээлэл байрлуулах	Тэсрэх материалын агуулах	3,000,000	Уулын ажил эхлэхэд	ХАБЭА-н тухай хууль

	Аврах гарцын чиглэлийг ил харагдахуйц байрлуулах Асгаралтын үед ашиглах шингээгч материал байрлуулах				
	Химийн бодисыг ХАЛМ-д заасны дагуу хадгалах, Мэдээ тайланг БОАЖГ-т хүргүүлэх	Тэсрэх материалын агуулах	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	ХАБЭА-н төлөвлөгөө	ХАБЭА-н тухай хууль
Бичиг баримт бүрдүүлэх	Дуут дохио суурилуулах Гал унтраагуур, галын сараа байрлуулах Галын дүгнэлт гаргуулах	Тэсрэх материалын агуулах	3,000,000		ХАБЭА-н тухай хууль
Төслийн болзошгүй эрсдлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нэг жилийн нийт зардал:				ХАБЭА-н зардалаас	

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Энгийн хог хаягдлын гэрээг сумын засаг даргатай байгуулж, гэрээний дагуу ажиллах, төлбөр хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Кемпийн хог хаягдал	Тн	300,000	Жилд 1 удаа төлбөр төлнө	1,200,000	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль

2		Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах хог хаягдлыг дахивар авах цэгт нийлүүлэх		Тн	200,000	4	800,000		
3		Хог хаягдлын ангилах, ачих цуглуулах, технологид нийцсэн хогийн сав байрлуулах							
4		Төслийн үйл ажиллагаанд тохирсон цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглалтад оруулах					Гэрээний дүнгээр		
5		Бохир усанд шинжилгээ хийлгэх MNS 6734 2018 стандартад нийцсэн усыг зам талбайн усалгаанд ашиглах	Цэвэрлэх байгууламж	Тн	50,000	4	200,000		
6		Стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонг булж, байгальд ээлтэй	Кемпийн аварийн 00-г MNS 5924 2015 стандартын шаардлагад	ш	20,000,000	1	20,000,000		

		шийдэл бүхий жорлон барих	нийцүүлэн барих						
7	Аюултай	Эрх бүхий байгууллагад ААХ- г нийлүүлэх гэрээ байгуулах, Эрүүл мэндийн газартай тусгай хог хаягдлын гэрээ байгуулах	Төхөөрөмжөөс гарах АХХ, ШТМ-ын АХХ,				3,800,000		
8		АХХ-г хаягдлыг бүртгэх, тогтоосон хугацаанд тээвэрлүүлэх	Үйлдвэрлэлийн хог хаягдал, ШТМ-н хаягдал	тн			Гэрээний дүнгээр		
9	Хог хаягдлын ангилаан ялгах дадал зуршил хэвшүүлэх	Гадаад орчны хог хаягдлыг түүх, (Иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох)	Кемп-Уурхай хооронд	улирал	500,000	2	1,000,000	2024 оны 1 ба 3 дугаар улирал	
10		Сургалт зохион байгуулах	Шинэ ажилтны сургалтын Байгаль хамгаалах хөтөлбөрөөр нийт ажилчдад сургалт мэдээлэл хүгэх					Тогтмол	
	Нийт	7,000,000							

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөрсний физик, химийн шинж чанар (Кемпийн хог хаягдлын цэгийн орчмоос нянгийн шинжилгээ хийлгэх)	1.Уурхайн талбай (эвдрэлд орсон газар) зам дагуу, 2.кемпийн хог хаягдлын цэгийн ойролцоо 3.техникийн засвар үйлчилгээний газрын ойролцоо 4. Шимт хөрсний овоолго 5. Хөндөгдөөгүй газарт	Жилд 2 удаа	1	2,000,000	2,000,000		Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
2	1.Ундны усны ерөнхий химийн шинжилгээ, нянгийн шинжилгээ 2.Ахуйн бохир усны шинжилгээ	1.Ундны ус 2.Ахуйн бохир ус 3. Сумын худаг 4. Булаг	Үйл ажиллагаа явуулах үед	1	1,500,000	1,500,000		Ундны усны чанарын стандарт MNS 900:2018 Ариутгах татуургад нийлүүлэх бохир усны стандарт MNS 6561 2015
3	Агаар дахь Тоос pm 2.5 pm 10 Нийт тоос NO3	1.Уурхайн талбай 2. Кемп 3.Нөлөөлөлд өртөөгүй талбай		1	2,000,000	2,000,000		Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007

								MNS:4048-88. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга.
4	Мониторингийн цэгүүдийн байршил тогтоож, тэмдэгжүүлэх	Дээж авах цэгүүдэд	2024 оны Здугаар улирал	1	1,500,000	1,500,000		
	Нийт					7,000,000		



13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	6	7
1.	Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;	Гэрээний дагуу	2024 оны 1 дүгээр улиралд	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн Орон нутагтай харилцах алба	БИНХ-д танилцуулга хүргэх
2.	Орон нутгаас ажиллаж байгаа ажилчид, сумын иргэдэд компаний мэдээлэл болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг танилцуулах	1,000,000	Үйл ажиллагааны туршид	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн Орон нутагтай харилцах алба	БИНХ-д танилцуулна
3.	Тэмдэглэлт өдрүүдэд байгаль хамгаалах арга хэмжээ зохион байгуулах Дэлхийн усны өдөр, Мод тарих үндэсний өдөр		3 дугаар сарын 22 5 дугаар сарын 2 дугаар дооо хоног	Уурхайн дарга Байгаль орчны мэргэжилтэн	Сумын БОХУБ, байцаагч нартай хамтран зохион байгуулах
4.					
	Нийт	1,000,000			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгс	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
№	1	2	3	4	5	6	7
1	Шинэжинст сумын БОХУБ болон засаг даргад урьдчилсан тайлан хүргүүлэх	Танилцуулга, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	2024 оны 10 дугаар сарын 15		Байгаль орчны мэргэжилтэн Уурхайн дарга	Сумын тамгын газар
2	Баянхонгор аймгийн БОАЖГ-т хүргүүлэх	Танилцуулга, Илтгэл	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	2024 оны 10 дугаар сарын 30		Байгаль орчны мэргэжилтэн Уурхайн дарга	Уурхайн оффис
3	БОАЖЯ-аар баталгаажуулах	Цахим	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	2024 оны 10 дугаар сарын 30		Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт						

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал / төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	40,000,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	22,000,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил	27,000,000
4	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,000,000
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардлаас
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7,000,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	7,000,000
8	БОМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,000,000
	<b>Нийт зардал</b>	<b>105,000,000</b>